



Үнэт цаасны зах зээлд аудит, хөрөнгийн  
үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр  
бүртгэсэн компаниудын талаарх өнөөгийн байдал

2018

- Өнөөгийн нөхцөл байдал
- Зайны хяналтын дүгнэлт
- Санал, дүгнэлт

# Өнөөгийн нөхцөл байдал

УИХ-аас Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг 2013 онд баталж, үнэт цаасны зах зээлд оролцогчид аудит, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх этгээдээр бүртгэх харилцааг зохицуулсан журмуудыг Хорооны хуралдаанаар баталж, мөрдүүлснээс хойш бүртгэлтэй этгээдийн тоо дараах байдалтай байгаа бөгөөд бүртгэлтэй байгаагаас өнгөрсөн 5 жилийн хугацаанд нэг ч компанийг бүртгэлээс хасаагүй байна.

*Хүснэгт 1. Бүртгэлтэй болон хүсэлтээ ирүүлсэн хуулийн этгээдийн тоо*

| Бүртгэлийн төрөл  | 2018 оны 6 дугаар сарын<br>байдлаарх бүртгэлтэй<br>этгээдийн тоо | 2018 онд бүртгүүлсэн<br>этгээдийн тоо | Бүртгүүлэхээр хүсэлт ирүүлэн,<br>хянагдаж байгаа |
|---|--|---------------------------------------|--|
| Үнэт цаасны зах зээлд оролцогчид<br>аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн<br>этгээд | 52   | 2                                     | 2  |
| Үнэт цаасны заха зээлд оролцогчид<br>хөрөнгийн үнэлгээ хийх хуулийн<br>этгээд   | 23   | 2                                     | 0  |

# Өнөөгийн нөхцөл байдал

Хүснэгт 2. Бүртгүүлэх зөвшөөрөл авсан байдал оноор

| Он   | Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд | Үнэт цаасны заха зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээ хийх хуулийн этгээд |
|------|---|---|
| 2012 | 8   | 8   |
| 2013 | 2   | 6   |
| 2014 | 15  | 1   |
| 2015 | 11  | 5   |
| 2016 | 8   |   |
| 2017 | 6   | 1   |
| 2018 | 2   | 2   |
| Нийт | 52  | 23  |

Мөн үнэт цаасны зах зээлд оролцогчдод аудитын үйлчилгээ үзүүлэх этгээдээр бүртгүүлсэн мөн даатгалын байгууллагад аудит хийх эрх авсан **30** компани давхар бүртгэлтэй байна. Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх этгээдээр бүртгүүлсэн мөн даатгалын салбарт даатгалын хохирлын үнэлгээ хийх эрх авсан "Арвижих эстимейт" ХХК, "Гэрэгэ Эстимэйт" ХХК, "Итгэлт Эстимэйт" ХХК, "Лэндс" ХХК, "Файн Эстимэйт" ХХК гэсэн нэр бүхий **5** компани байна.

# Зайны хяналтын дүгнэлт

Санхүүгийн зохицуулах хорооноос 2017 оны 11 дүгээр сард үнэт цаасны зах зээлд оролцогчид аудит, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэхээр бүртгүүлсэн компаниудад зайны хяналтыг хийж гүйцэтгэсэн ба ирүүлсэн мэдээллүүдийг хянаж үзэхэд дараах байдалтай байна.


*Хүснэгт 3. Зайны хяналтын дүгнэлт*

|                   | Бүртгэлтэй | Тайлан ирүүлсэн | Бүртгэлээс хасах нөхцөл үүссэн | Нийтлэг зөрчил  |
|-------------------|------------|-----------------|--------------------------------|---|
| Аудитын үйлчилгээ | 50         | 35              | 21                             | -боловсон хүчний шаардлага хангахгүй.<br>-хяналт, шалгалтаас зайлсхийсэн. |
| Хөрөнгийн үнэлгээ | 21         | 20              | 11                             | /Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 86.1.1, 33.7.3/                    |

# Зайны хяналтын дүгнэлт

2015-2016 оны санхүүгийн тайлангаа ирүүлсэн **35 аудитын** компанийн санхүүгийн гол үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

График 1. Хувь нийлүүлсэн хөрөнгө, компанийн тоо



Хүснэгт 4. Үйл ажиллагааны орлогын тархалт

| Үйл ажиллагааны орлого | 2016      | 2015      |
|------------------------|-----------|-----------|
| 50 хүртэлх сая         | 6         | 4*        |
| 50 сая-100 сая         | 7         | 11        |
| 100 сая-150 сая        | 9         | 7         |
| 150 сая-200 сая        | 4         | 5         |
| 200 сая-300 сая        | 2         | 2         |
| 300 сая-400 сая        | 1         | 1         |
| 400 саяас дээш         | 6         | 5         |
| <b>Бүгд</b>            | <b>35</b> | <b>35</b> |


Хүснэгт 5. Ашигт ажиллагааны үзүүлэлт

| Цэвэр ашиг            | 2015 он | 2016 он |
|-----------------------|---------|---------|
| Ашигтай ажилласан     | 18      | 22      |
| Алдагдалтай ажилласан | 17      | 13      |

# Зайны хяналтын дүгнэлт

Хөрөнгийн үнэлгээний 20 компани 2015-2016 оны санхүүгийн байдлын тайлангаа ирүүлснээс хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, үйл ажиллагааны орлогын дүн болон ашигтай ажилласан компаниудын тархалтыг харуулвал дараах байдалтай байна. Үүнд:

График 2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, компанийн тоо



Хүснэгт 7. Ашигт ажиллагааны үзүүлэлт

| Цэвэр ашиг            | 2015 он | 2016 он |
|-----------------------|---------|---------|
| Ашигтай ажилласан     | 12      | 11      |
| Алдагдалтай ажилласан | 11      | 9       |

Хүснэгт 6. Үйл ажиллагааны орлогын тархалт

| Үйл ажиллагааны орлого | 2016      | 2015      |
|------------------------|-----------|-----------|
| 30 хүртэлх сая         | 3         | 5         |
| 30 сая-500 сая         | 5         | 4         |
| 50 сая-70 сая          | 3         | 4         |
| 70 сая-100 сая         | 2         | 1         |
| 100 саяас дээш         | 7         | 6         |
| <b>Нийт</b>            | <b>20</b> | <b>20</b> |

- Аливаа хөрөнгө оруулагчид нь хувьцаат компанийн үйл ажиллагаанд хийгдсэн хөндлөнгийн хараат бус дүгнэлтэд тулгуурлан шийдвэрээ гаргадаг.
- Манай орны үнэт цаасны зах зээлд 2013 оноос хойших хугацаанд Сангийн яамнаас тусгай зөвшөөрөлтэй аудит, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх компаниуд үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгүүлэх сонирхол нэмэгдэж байна. Хөндлөнгийн үнэлгээний байгууллагуудын тоо нэмэгдэж буй хэдий ч мэргэжлийн зуучлагч байгууллага, хувьцаат компаниудын тоо төдийлөн сүүлийн 3 жилд нэмэгдээгүй байгаа нь хөндлөнгийн дүгнэлт гаргагч компаниуд үйлчилгээний үнэ ханшаар өрсөлдөх сэдлийг бий болгож байна.
- Үйлчилгээний үнэ ханшаар өрсөлдөх нь эргээд хөрөнгө оруулагч, харилцагчид шийдвэр гаргахад шаардлагатай хөндлөнгийн дүгнэлтийн найдвартай байдлыг алдагдуулж, санхүүгийн хараат байдалд оруулах бөгөөд үнэт цаасны зах зээлийн мэдээлэл тайлагнал, засаглалыг сулруулах, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхлыг бууруулж, зах зээлийн хэвийн тогтвортой байдлыг сулруулах эрсдэлийг дагуулж байна.



- Мөн олон улсад энэ хөндлөнгийн дүгнэлт өгөх байгууллагуудад тавих хяналтыг мөн стангдартчилж байна. Тухайлбал Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO)-аас 2002 онд “Аудиторуудад тавигдах хяналтын зарчим” /Principle for Auditor Oversight/-ыг боловсруулан гаргасан байдаг. Аудитын компаниуд, аудитын үйлчилгээ үзүүлж буй этгээдүүдэд зохицуулагч байгууллагаас тодорхой түвшний хяналтыг тавих нь зүйтэй гэж үздэг бөгөөд энэ нь дараах шалтгаантай: Үүнд:
  - Аливаа хөрөнгийн зах зээлд итгэх хөрөнгө оруулагчийн итгэл хамгийн чухал бөгөөд ирээдүйн хөрөнгө оруулагч, одоогийн хувьцаа эзэмшигч зэрэг мэдээлэл хэрэглэгчдийн хувьд хувьцаат компани зэрэг хөрөнгийн зах зээл дээр нээлттэй арилжаалагддаг компанийн хувьцааны санхүүгийн зураглал, мэдээлэл найдвартай, итгэл төрүүлэхүйц байх шаардлагатай. Иймд аудитын компанийн хариуцлага өндөр байдаг.
  - Хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын зорилго нь хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, зах зээл шударга, үр ашигтай, нээлттэй эсэхийг нягталж, системийн эрсдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэх юм. Энэхүү зорилгын хүрээнд хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөөлөх мэдээллийн орц болох зохистой, шаардлага хангасан аудитын дүгнэлт нь хөрөнгө оруулагчийн зохистой шийдвэр гаргахад нөлөөлөх, зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлж, зах зээлийн хөрвөх чадвар, үр ашгийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.
  - Аудитын компаниуд болон компанийн хараат бус аудиторууд нь тус компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал нь олон улсын стандартын дагуу үнэн зөв тайлагнасан эсэхийг нягтлах, хянах мэргэжлийн болон нийгмийн өндөр хариуцлагатай ажил гүйцэтгэдэг байна.

Иймд зайны хяналтын үр дүн, одоогийн нөхцөл байдал, олон улсын чиг хандлага зэргийг харгалзан үзэж бид дараах арга хэмжээг авч ажиллах саналтай байна.

- Хороонд бүртгүүлсэн аудит, хөрөнгийн үнэлгээ, хууль зүйн компаниудын үйл ажиллагаанд Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн холбоотой хамтарсан ажлын хэсгийг байгуулж, чанарын хяналтыг 2018 онд багтаан хэрэгжүүлэх;
- Шаардлага хангахгүй болсон аудит, үнэлгээ, хуулийн компаниудыг бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулах;
- Цаашид чанарын хяналтын чиглэлээр Хорооны холбогдох газар хэлтсүүдийн мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэх;
- Бүртгэлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай эргэх холбоо бүхий тайлан мэдээ ирүүлэх, хаяг, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөн тохиолдолд Хороонд мэдэгдэх зэрэг зохицуулалтыг хууль тогтоомж, журам, зааварт тусгах.



**Анхаарал хандуулсанд  
баярлалаа**